**БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 28 өдөр Дугаар А/191 Улаанбаатар хот

"Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд
хурлын тоног төхөөрөмж худалдан авах"
барааг ашиглалтад хүлээн авах
Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Дүүргийн төсвийн хөрөнгөөр "Өнө тэгш арвижих" ХХК-ны гүйцэтгэсэн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хурлын тоног төхөөрөмж худалдан авах." барааг ашиглалтад хүлээн авах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | | |
|---|---|---|
| Ажлын хэсгийн ахлагч: | Л.Санжийжамц | Засаг даргын Тамгын газрын даргаГишүүд: |
| | Д.Хүрэлбаатар | Засаг даргын Тамгын газрын Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга |
| | П.Дэлгэр | Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн эрхлэгч, нярав |
| | Н.Батболд | Засаг даргын Тамгын газрын Мэдээлэл технологи хариуцсан мэргэжилтэн |
| Нарийн бичгийн дарга: | Р.Буянжаргал | "Өнө тэгш арвижих " ХХК-ны захирал |

2.Ашиглалтад хүлээн авах ажлыг холбогдох хууль, журмын дагуу чанар гүйцэтгэлд хяналт тавин хүлээн авах ажлыг зохион байгуулж, эргэн танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА А.СҮХБОЛД

AJIL\2023 он ажил\захирамж

1123000328